



Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөлийн
2022 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн хурлын
08/2022 тоот тогтоолын 2. хавсралт

МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Геологийн салбарт ажиллаж буй төрийн ажилтан, хувийн хэвшлийн удирдлага /цаашид удирдах ажилтан гэнэ/ болон мэргэшсэн мэргэжилтэн, зөвлөхийн /цаашид мэргэшсэн мэргэжилтэн гэнэ/ ба мэргэжилтнүүдийн үйл ажиллагаандаа баримтлах харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээг энэхүү “Мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн дүрэм” –ээр /цаашид ёс зүйн дүрэм гэнэ/ зохицуулна.

1.2 Монгол Улсын Үндсэн хууль, Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Монгол улсын усны хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон геологийн салбартай холбоотой дүрэм, журам, стандарт, заавар, зөвлөмжүүд нь ёс зүйн дүрмийн эрх зүйн үндэс болно.

1.3 Мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг мөрдлөг болгож ажиллана.

- Эх оронч байх
- Үнэнч, шударга, хянамгай байх
- Баримт нотолгоонд тулгуурласан бодит байх,
- Хараат бус байх
- Хууль дээдлэх, дүрэм, журам, стандарт, зааврын дагуу хийх
- Мэргэшсэн байх
- Мэдээллийн нууцлалыг хадгалах
- Мэргэжлийн нэр хүндийг дээдлэх
- Ур чадвар, мэдлэг, туршилагаа байнга дээшлүүлэх
- Залгамж халаагаа сургах, мэргэшүүлэх

1.4 Энэ дүрмийн хэрэгжилтийг хангах, өргөдөл гомдлыг хянан шалгах зорилгоор ёс зүйн хороог байгуулна. /ЁЗХ-ны бүрэлдэхүүнийг 2 жил тутамд 1 удаа өөрчилнө/

1.5 Мэргэшсэн мэргэжилтэн нь ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөж ажиллана.

1.6 Ёс зүйн дүрэм нь мэргэшсэн мэргэжилтний мэргэжлийн бүхий л үйл ажиллагаанд, тухайн үйл ажиллагаа нь хаана, хэзээ явагдсанаас үл хамааран үйлчилнэ.

1.7 Мэргэшсэн мэргэжилтний эрх авч буй хүн бүхэн энэхүү ёс зүйн дүрмийн танилцуулга-сургалтад 100% хамрагдан, дагаж мөрдөнө.

1.8 Мэргэшсэн мэргэжилтэн нь ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлэн тангараг өргөж, баталгаат гарын үсгээ зурна.

1.9 МГХНЗ-ийн ажилтнууд, ММЗ-ийн гишүүд, төлөөлөх зөвлөлийг бүрдүүлсэн холбоодын удирдлага, мэргэжлийн холбоодын дарга, гишүүд ба нарийн бичгийн дарга нар, ЁЗХ –ны гишүүд нь мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн дүрмийн танилцуулга-сургалтад жилд нэг удаа 100% хамрагдаж, гарын үсэг зурна.

1.10 МГХНЗ нь мэргэшсэн мэргэжилтнүүдийн төсөл, хөтөлбөр удирдах эрх зүйн чадамжтай болох, шинжээч хийх эрхтэй тухай төрийн захиргааны байгууллагад илгээх тодорхойлолтдоо ёс зүйн хорооны саналыг тусгана.

1.11 Мэргэшсэн мэргэжилтний хүлээсэн үүргээ дарамт шахалтгүйгээр биелүүлэх, ажиллах тал дээр МГХНЗ болон ММЗ, ЁЗХ анхаарал тавьж, эрхийг нь хамгаалж ажиллана.

1.12 Мэргэжилтнүүдийг харьяалах аливаа удирдах ажилтны үйл ажиллагаандaa баримтлах харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээ нь энэ дүрмийн заалтуутдай салшгүй холбогдох ба зүй бус үйл ажиллагааг ёс зүйн дүрмийг зөрчсөнд тооцож харьяалагдах субъектэд нь хандана.

ХОЁР. МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

2.1. **Мэргэшсэн мэргэжилтэн нь эх оронч үзлийг эн тэргүүнд тавьж үндсэн хуулийн суурь зарчмуудыг мөрдлөг болгож ажиллана.**

2.1.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа Монгол улсын эрх ашгийг тэргүүнд тавьж ажиллана.

2.1.2. Газрын хэвлий, түүний баялаг төрийн, нийтийн өмч байх үндсэн хуулийн заалтыг мөрдлөг болгон ажиллана.

2.2. **Мэргэшсэн мэргэжилтэн нь хувь хүний үнэнч, шударга, хянамгай байдал, мэргэжлийн ба ёс суртахууны дээд түвшинг баримталж дагаж мөрдөнө.**

2.2.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь гагцхүү баримт, нотолгоонд суурилсан бодит байдлыг үнэлж, үнэн зөв мэдээллийг боловсруулж шударгаар ажиллана.

2.2.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь үнэнч, шударга, хянамгай байдал, тал тохой татахгүй байх, чин сэтгэлээсээ хандах, итгэл үнэмшилдээ тууштай байх зэрэг зан үйлийг амьдралын хэв маяг болгохыг баримтална.

2.2.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь геологийн тогтоц, гидрогоеологийн нөхцөл, гарал үүслийн нарийн төвөгтэй ба тодорхойгүй байдлуудыг хүлээн зөвшөөрч, мэдэгдэж байгаа зүйлийн зэрэгцээ үл мэдэгдэх зүйлийн талаар ч таамаглаж, мэдээлж, зөвлөнө.

2.2.4. Мэргэшсэн мэргэжилтэн нь ажил олгогч болон үйлчлүүлэгчдээ мэргэжлийн ёс зүйн үндсэн үүргийнхээ хүрээнд чадварлаг үйлчилнэ.

- 2.2.5. Мэргэшсэн мэргэжилтэн нь гишүүд, мэргэжлийн хамт ажиллагсдынхаа талаар бусадтай харьцахдаа тодорхой, үнэнч, шударга, нээлттэй байх зарчмыг баримтална. илэн далангүй байна.
- 2.2.6. Мэргэшсэн мэргэжилтэн нь үйл ажиллагаагаа шударгаар явуулахад нөлөөлөхүйц бодит эсвэл болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн талаар өөрийн үйлчлүүлэгч болон ажил олгогчид мэдээллэнэ.
- 2.2.7. Мэргэшсэн мэргэжилтэн нь өөрийн эзэмшилд эсвэл хяналтад байгаа, тухайн ажил эрхлэхтэй шууд болон шууд бусаар холбоотой байж болох аливаа ашигт малтмалын болон бусад ашиг сонирхлынхоо талаар ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчдэдээ мэдээллэнэ.
- 2.2.8. Мэргэшсэн мэргэжилтэн нь өөрөө тайланг нь гаргаж буй аливаа эд хөрөнгөөс хувь хүртэх эрхтэй эсвэл түүнээс хүлээгдэж буй хувийн ашиг сонирхолтой бол энэ талаарх баримтыг тухайн тайланд тусгана.
- 2.2.9. Аливаа нэг ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчид ажилтнаар буюу гэрээгээр ажиллаж буй мэргэшсэн мэргэжилтэн нь тэдэнтэй ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй өөр этгээдтэй бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр уулзалт зохион байгуулж болохгүй.

2.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь үйл ажиллагаагаа хэн нэгнээс хараат бусаар зөвхөн баримт иотолгоонд тулгуурласан бодит байхаар ажиллана.

- 2.3.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь ажил олгогч болон үйлчлүүлэгчийн удирдлага, заавраар хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх, дүгнэлт гаргахгүй байх үүрэг хүлээнэ.
- 2.3.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд тайлан, дүгнэлт, шүүмж бичих, төсөл боловсруулах, үнэлж цэгнэхдээ зөвхөн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, туршлагынхаа хэмжээнд хэнээс ч хамааралгүйгээр хийж гүйцэтгэнэ.

2.4. Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, стандарт, зааврын хүрээнд хуулийг дээдлэн үйл ажиллагаагаа явуулна.

- 2.4.1. Мэргэшсэн мэргэжилтэн хууль тогтоомж, журам, дүрэм, стандарт, заавар, шаардлагуудыг дагаж мөрдөнө.
- 2.4.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь аливаа хууль бус ажиллагаанд санаатайгаар оролцох, үйлдэл хийх, өөрийн боловсруулсан тайлан болон бусад бичиг баримтыг хууль бус зорилгоор ашиглуулахыг хориглоно.
- 2.4.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь төрийн албан тушаалтны шийдвэрт нөлөөлөх зорилгоор түүнд бэлэг сэлт, төлбөр, бусад үнэт зүйл санал болгох ёсгүй ба мөн албан тушаал хашиж буй мэргэшсэн мэргэжилтэн нь аливаа шийдвэрт нөлөөлөхүйц төлбөр, бэлэг сэлт хүлээн авахгүй.
- 2.4.4. Мэргэшсэн мэргэжилтэн нь ажил олгогч, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсдын аливаа хууль бус шийдвэр, үйлдлийн талаар мэдээлэл авсан бол тэрээр үүнийг ил тод болгох, дээрх үйлдэл нь нийгэмд, олон

нийтийн аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайханд шууд нөлөөлөхүйц бол холбогдох албан тушаалтуудад мэдээлэх үүрэгтэй.

2.4.5. Ажлын байр, үйл ажиллагаа явуулж буй орчинд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, дарамтлах үйлдлийг нэн даруй таслан зогсоох талаар арга хэмжээ авах, эрх баригчдад мэдэгдэх хэрэгтэй. Ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэх, хамт ажиллагсад эсвэл ажилтнуудынхаа дарамт гомдлыг үл тоомсорлох нь мэргэжлийн бус бөгөөд ёс зүйгүй юм.

2.5. Мэргэшсэн мэргэжилтэн нь өөрийн үйл ажиллагаандаа цаг ямагт мэргэжлийн нэр хүндийг дээдлэн ажиллана.

2.5.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь геологийн ба салбар мэргэжлийг нийгэмд улам их ашигтай болгохын тулд түүнийг илүү сайжруулахад анхаарна.

2.5.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь ур чадвар, мэдлэг, туршлагаа байнга дээшлүүлэхийг цаг ямагт эрэлхийлнэ.

2.5.3. Мэргэшсэн мэргэжилтэн мэргэжлээрээ бусадтай хамтран ажиллаж, геологийн мэдлэгийг түгээхэд дэмжлэг үзүүлэх, геологийн боловсрол, судалгаа, сургалт, практикийн стандартыг сайжруулах, залгамж халаагаа сургах, мэргэшүүлэх тал дээр анхаарч ажиллана.

2.5.4. Мэргэшсэн мэргэжилтэн нь олон нийтийн болон төрийн байгууллагуудыг төөрөгдүүлсэн, хэтрүүлсэн эсвэл үндэслэлгүй мэдэгдлээс зайлсхийнэ.

2.5.5. Мэргэшсэн мэргэжилтэн нь геологийн ба салбар мэргэжлийн талаар эсвэл өөрийн болон бусад мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвартай холбоотой худал мэдээлэл, мэдэгдэл гаргаж тараахгүй байна.

2.5.6. Мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжил нэгтэй хамтран ажиллагчийн талаар хуурамч мэдүүлэг, төөрөгдүүлсэн, хэтрүүлсэн, гүтгэсэн эсвэл үндэслэлгүй мэдэгдэл гаргахгүй байх. Үзэл бодлын талаарх мэдэгдэл нь шинжлэх ухааны зарчмууд дээр үндэслэсэн, хязгаартай байх бөгөөд мэдэгдлийг хүндэтгэлтэй бас мэргэжлийн үүднээс гаргана.

2.5.7. Мэргэшсэн мэргэжилтэн нь иргэний болон мэргэжлийн хувьд олон нийтийн ажилд оролцдог, геологийн үйл ажиллагаа, явцуудын амьдралд үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтэд сурталчлах ажлыг дэмжин ажиллана.

2.5.8. Мэргэшсэн мэргэжилтэн нь ур чадвар, мэдлэг, туршлагын тусlamж хүссэн аливаа этгээдэд үнэнч шударгаар, зохих урамшуулал ба ажлын хөлстэйгөөр туслах үүрэгтэй.

2.5.9. Мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхээр Ёс зүйн хорооноос томилогдсон мэргэжилтэн нь уг асуудалд мэргэшлийн ур чадвар, туршлага, мэдлэгээ дайчлан үнэнчээр тусална.

2.6. Мэргэшсэн мэргэжилтэн нь өөрийн үйл ажиллагаатай холбоотойгоор нууцлах зайлшгүй шаардлагатай мэдээллийн нууцлалыг чанд хадгалах ёстай.

2.6.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь ажил олгогч, үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэх явцдаа олж авсан аливаа нууц мэдээллийг ажил олгогч, үйлчлүүлэгчээс урьдчилан зөвшөөрөл авсан, эсвэл хуульд заасны дагуу задруулах шаардлагатайгаас бусад тохиолдолд тухайн нууц мэдээллийг ажил олгогч, үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж, хохирол учруулах аливаа хэлбэрээр ашиглахгүй.

2.6.2. Ажил олгогч, үйлчлүүлэгчтэй холбоотой шалгалт хийсэн мэргэшсэн мэргэжилтэн нь цаашдаа ашиг сонирхлын зөрчил үүсэх нь тодорхойгүй бол тухайн ажил олгогч, үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр олж авсан мэдээллээс эдийн засгийн ашиг олохыг эрэлхийлэхгүй.

2.6.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь ажил олгогч, үйлчлүүлэгчийн урьдчилсан мэдэгдэл ба зөвшөөрөлгүйгээр тэдний аливаа мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй.

2.7. Мэргэшсэн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаандын өгч байгаа үнэлгээ, дүгнэлт нь мэргэшсэн, мэргэжлийн дээд түвшинд хийгдсэн байна.

2.7.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь ажил олгогч, үйлчлүүлэгчдээ мэргэжлийн хувьд зохих ёсоор үйлчилнэ.

2.7.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь зөвхөн мэргэжлийн үйлчилгээ ба зөвлөгөө өгөх ёстой бөгөөд аливаа мэргэжлийн зөвлөгөө нь түүний хувийн мэргэжлийн ур чадвараас гадуур байгаа тохиолдолд ажил олгогч, үйлчлүүлэгчдэд энэ талаар мэдэгдэнэ.

2.7.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь түүнээс шаардагдаж буй аливаа санал, тайлан нь ямар зорилгоор ашиглахыг харгалзан, зохих хэмжээний мэдээлэл аваагүй тохиолдолд мэргэжлийн дүгнэлт өгөх, тайлан гаргахгүй.

2.7.4. Мэргэшсэн мэргэжилтэн нь тухайн ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгийн сайн хангах тохиолдолд л бусад экспертууд ба мэргэжилтэнтэй тэднийг хамтран ажиллах зөвлөгөө өгөх ба ийм хамтын ажиллагаанд татан оролцуулна.

2.7.5. Ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэг нь мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээтэй нь зөрчилдсөн гэж үзсэн мэргэшсэн мэргэжилтэн нь ийм таагүй нөхцөлийг залруулах эсвэл ажил үүргээсээ татгалзаж болно.

2.7.6. Мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжил нэгтэй хамт ажиллагсдын эрх, ашиг сонирхол, оруулсан хувь нэмрийг хүндэтгэж хүлээн зөвшөөрнө.

2.7.7. Мэргэшсэн мэргэжилтэн нь мэргэжлийн даалгаврыг гүйцэтгэх явцад бусдын хийж гүйцэтгэсэн ажлыг хүндэтгэх бөгөөд бусдад зориулсан ямар нэгэн үнэлгээг өөртөө хүлээн авахгүй.

2.7.8. Мэргэшсэн мэргэжилтэн нь амаар болон бичгээр үйлдсэн мэдэгдэлдээ бусдын санааг хулгайлахгүй ба бусдын бэлтгэсэн материалыг зохиогчийг нь дурдалгүйгээр ашиглахгүй.

ГУРАВ. ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ, ДҮРМИЙГ ЗӨРЧИГСДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

3.1. Удирдах ажилтан, мэргэшсэн мэргэжилтэн, мэргэжилтэн нь энэхүү дүрмийн заалтыг зөрчсон болох нь ёс зүйн хороо болон бусад холбогдох байгууллагуудын шийдвэрээр баталгаажсан тохиолдолд сахилгын хариуцлага хүлээнэ.

3.2. Сахилгын хариуцлагыг ёс зүйн хорооны дүгнэлт болон бусад холбогдох байгууллагуудын шийдвэрийг үндэслэн МГХНЗ –ийн даргын тушаалаар ноогдуулна.

3.3. Сахилгын хариуцлага хүлээх мэргэшсэн мэргэжилтэнд дор дурдсан хэлбэрийн сахилгын шийтгэлийг ноогдуулна.

3.3.1. Сануулах,

3.3.2. Мэргэшсэн мэргэжилтний эрхийг 3-6 сар хүртэл хугацаагаар хасах,

3.3.3. Мэргэшсэн мэргэжилтний эрхийг цуцлах, нийтэд зарлан мэдээлэх

3.4. Сахилгын зөрчил гаргаснаас хойш зургаан сар, илрүүлснээс хойш нэг сарын дотор сахилгын шийтгэл ноогдуулна.

3.5. Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ноогдуулж болохгүй ба дараагийн шатны шийтгэлийг хэрэглэнэ.

3.6. Сахилгын шийтгэл ноогдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно.

3.7. Мэргэшсэн мэргэжилтний эрхийг шууд цуцлах үндэслэлүүд:

3.7.1 Мэргэшсэн мэргэжилтэн болон горилогч нь хүндэтгэх шалтгаангүйгээр гэрчилгээ хүлээн авахгүй, тангараг өргөлгүй ажлын 22 өдөр болсон бол ажлын 10 өдрийн дотор мэргэжилтний ёс зүй хуудсаар нийтийн дунд зарлаж 1.7 ба 1.8 заалтуудыг зөвшөөрөгүй гэж тооцон ТББ –аас эрхийг нь хүчингүй болгоно,

3.7.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь нөөцийн тооцоололтой ба тооцоололгүй тайлан, түүнтэй адилтгах бичиг баримт материалд илт худал мэдээлэл оруулсан, ашигласан, засварласан үүний улмаас улсад болон хувь хүн, компанид онц их хэмжээний хохирол учирсан болох нь тогтоогдсон,

3.7.3 Шинжээчээр ажиллахдаа баримт материалыг гүйцэд шалгаагүйн улмаас илт хуурамч дүгнэлт гаргаж, тайлан нь хамгаалагдсан,

3.7.4 Геологийн судалгаа, эрэл, хайгуул, олборлолтын үеийн ажлаар гарсан үр дүнг нуун дарагдуулсан,

3.7.5 Хамтран ажиллагсдаа дарамтлах, ялгаварлан гадуурхах зэрэг үйлдлүүд багтана.

ДӨРӨВ. БУСАД

4.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь эдгээр ёс зүйн хэм хэмжээг заавал үлгэр жишигчээр сахин мөрдөхөөс гадна бусад мэргэшсэн мэргэжилтэнд эдгээр хэм хэмжээнд тууштай хандахыг зөвлөж, мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар дэмжинэ.

4.2. Энэхүү дүрмийг өөр мэргэшсэн мэргэжилтэн зөрчиж байгааг мэдэж байгаа бол уг зөрчлийн үндэслэлтэй нотолгоог МГХНЗ –д мэдэгдэнэ.

4.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь өөрийн үүргээ биелүүлэхэд ямар нэгэн дарамт үзүүлж, ёс зүйн хэм хэмжээг зөрчихийг тулгаж, эрх үүрэгт нь халдаж байгаа аливаа үйлдлийн талаар МГХНЗ –д шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй.

4.4. Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.